



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24-дэр

Дугаар 30

Есөнбулаг сум

Сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд төрийн албан хаагчдын ажлын сахилга хариуцлагыг дээшлүүлж, төрийн бүх ажил үйлчилгээг иргэдэд цаг хугацаанд нь түргэн шуурхай, жигд хүртээмжтэй, “Хүнд сурталгүй” хүргэж ажиллахыг төрийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

2. Иргэдэд төрийн үйлчилгээг хүнд сурталгүй хүргэж, ажлын сахилга хариуцлага, дэг журмыг ханган ажиллаж үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сар бүр сурталчилан, улирал тутам аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд мэдээлж, иргэдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.



ДАРГА Т.ГАНЗОРИГ